

# СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

## АХМАДУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон сайдын зөвлөлийн гишүүд ахмад дайчин чөлөөнд байгаа дэд хурандаа Т.Бат-Очир, хүний гавьяат эмч, чөлөөнд байгаа хурандаа Л.Жамбалжав, хүний гавьяат эмч, чөлөөнд байгаа дэд хурандаа Б.Оюунцэцэг нарын ахмадад хүндэтгэл үзүүлээ.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “1945 оны Чөлөөлөх дайнд Хээрийн засварын бүлэг, Цэнэгийн бүлэг болон Холбооны зангилааны гэрэлтүүлгийн бүлгийг удирдан оролцсон ахмад дайчин Т.Бат-Очирын 100 насны түүхт ой энэ сарын 15-ны өдөр тохиосон. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны зарлигаар чөлөөнд байгаа хурандаа, хүний гавьяат эмч Л.Жамбалжавт Төрийн соёрхол, чөлөөнд байгаа дэд хурандаа Б.Оюунцэцэгт “Хүний гавьяат эмч” цол тус тус хүртсэн баярт үйл явдлууд зэрэг тохиолоо. Үүнд миний бие болон сайдын зөвлөлийн гишүүд, салбарын нийт бие бүрэлдэхүүн та бүхэндээ хүндэтгэл үзүүлж, баяр хүргэж байгааг хүлээн авна уу” гээд ахмадуудад өргөмжлөл, үнэ бүхий дурсгалын зүйл гардуулав.

Ахмад дайчин Т.Бат-Очир “Өнөөдөр салбарын сайд, генерал, хурандаа нараасаа Төрийн соёрхолт, гавьяатуудын хамтаар хүндэтгэл хүлээн авч байгаадаа туйлын баяртай байна. Хүн ер нь ямар ч үед эрүүл байх нь чухал. Эрүүл мэндээ

анхаарна гэдэг амьдралын тулгуур чанар юм. Хүүхэд залуустаа эрүүл саруул байж, эх орныхоо хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулаарай гэж захимаар байна” гэв.

Үүний дараа чөлөөнд байгаа хурандаа, хүний гавьяат эмч Л.Жамбалжав “Энэ хүндэтгэлийг би цаашдын минь ажил, хөдөлмөрт уриалан дуудаж, урам өгсөн үйл явдал гэж харж байна. Нөгөө талаараа үүрэг даалгавар, өндөр хариуцлага юм. Өнөөдөр Батлан хамгаалах яаманд хүрэлцэн ирэхэд олон сайхан дурсамж нүдэнд минь тодорлоо. Энэ салбараар би туйлын их бахархдаг гэдгээ хэлье. Миний хувьд Цэргийн төв эмнэлэгт зөвлөхөөр ажиллаж эмчийнхээ үүргийг гүйцэтгэж байна. Цаашид ч өгсөн үүрэг даалгаврыг цэрэг хүний хувьд өдөр шөнийн аль ч үед биелүүлэхэд бэлэн” гэсэн юм.

Түүнчлэн чөлөөнд байгаа дэд хурандаа, хүний гавьяат эмч Б.Оюунцэцэг Цэргийн төв эмнэлгийн мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмчээр ажилласан 30 гаруй жилийн хугацаанд 12300 өвчтөнд эрчимт эмчилгээ сэхээн амьдруулах тусламж, үйлчилгээ үзүүлж, мэс засал, мэс ажилбарын үед 10250 хүнд мэдээгүйжүүлэг гардан явуулсан гэдгээ онцоллоо.

Төгсгөлд нь сайд Г.Сайханбаяр ахмадуудад хандан хүүхэд, залуусыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх үйлсэд нь амжилт хүсээд эрүүл энх байж, урт удаан наслахыг ерөөв.

## БАРИЛГАЧИН ДАЙЧИД НОМЫН ДУУ СОНСЛОО



ЗХЖШ-ын Барилга-Инженерийн цэргийн удирдах газраас “Цэргийн алба хаагчийн хөгжил-нийгмийн хариуцлага” сэдэвт цахим сургалтыг өчигдөр зохион байгууллаа. Тус сургалтад Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын бие бүрэлдэхүүн, харьяа ангиудын удирдлага, алба хаагчид хамрагдсан юм. Сургалтыг нээж тус газрын дарга, дэд хурандаа Д.Жаргалсайхан “Монгол Улсын хэмжээнд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан уг сургалтыг хойшлуулаад байсан бол өнөөдөр ийнхүү зохион байгуулж байна. Бидний хувьд тангараг өргөж, үүрэг хүлээсэн цэргийн алба хаагчид ч гэлээ нийгмийн харилцаанд бусдын л адил тэгш оролцдог. Хууль, дүрэм адилхан үйлчилдэг. Тийм учраас нийгмийн харилцаанд болж байгаа асуудлын талаар мэдлэг, мэдээллээ солилцож, ёс зүй, дүрэм журамд нийцэж амьдрах, бусадтай хөл нийлүүлэн алхах учиртай. Мэдээж үүрэг даалгавраа биелүүлэхийн зэрэгцээ бидний ард амьдрал байдаг гэдгийг ухамсарлах хэрэгтэй. Харилцааны явцад бий болдог хүндрэл, бэрхшээлүүдээс хувь хүний асуудал, албаны асуудал, гэр бүлийн асуудлууд үүсдэг. Эдгээрээс ангижирч, албан үүргээ амжилттай гүйцэтгэхийн тулд аливаа зүйлийг

сайтар төлөвлөж, харилцан ярилцаж, хамтарч ажиллах нь их чухал. Тийм учраас энэ төрлийн сургалтуудыг нийт бие бүрэлдэхүүнээс авсан судалгаанд тулгуурлан явуулахаар төлөвлөсөн. Цэргийн алба хаагчдын харилцааны зөрчил, ёс зүйн доголдол нь хувь хүний, ажил албаны гээд олон шалтгаанаас үүдэлтэй. Дээрх алдаа, дутагдлаас урьдчилан сэргийлэх үүднээс энэхүү сургалтыг зохион байгуулж байна. БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд ч энэ асуудалд анхаарал хандуулж, тус сургалтыг зохион байгуулах үүрэг, чиглэлийг өгсөн” гэдгийг онцоллоо.

Үүний дараа ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсийн дарга, цэргийн цагдаагийн дарга, хурандаа Д.Адъяабазар “Нийгмийн харилцаанд дахь цэргийн албан хаагчийн ёс зүй ба стресс, менежмент”, зохиолч, лектор Г.Мөнхөн “Хувь хүний болон өрхийн санхүүгийн төлөвлөлт”, Монголын гэр бүл судлаачдын мэргэжлийн холбооны тэргүүн Ж.Баясгалан “Аз жаргалтай гэр бүл-Гэр бүлийн эрүүл мэнд”, ЗХЖШ-ын Сургалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга, Цэргийн албаны хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Д.Өлзийбаяр, Наркологийн төвийн сэтгэл засалч Ч.Гантулга нар тодорхой сэдвийн хүрээнд лекц уншсан юм.



Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ерөнхий цэргийн офицерууд Ерөнхий цэргийн баярын өдрийг тохиолдуулан “Гранат мэргэн шидэлт”, “Гранат хол шидэлт”-ийн тэмцээнийг Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн сургалтын төвд 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдөр залуу офицер, ахлагч нарын дунд явууллаа.

Гранат мэргэн шидэлтийн төрлийн эхний 3 байрт Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ахлах ахлагч Э.Бямбацогт, Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн ахлах ахлагч Г.Багабанди, Зэвсэгт

хүчний 016 дугаар нэгтгэлийн ахлах ахлагч М.Алтанбагана нар шалгарав. Гранат хол шидэлтийн төрөлд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн дэслэгч С.Батмөнх, Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн ахлах ахлагч Э.Энхсайхан, Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн ахлах ахлагч Г.Багабанди нар бусдыгаа манлайллаа. Гранат шидэлтийн эмэгтэй төрөлд тэргүүн байрыг Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн дэслэгч Ч.Отгонбаяр эзэллээ.

### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ 4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 22

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 27	🌧️ 13

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.438.00	3.498.00
CNY 🇨🇳	441.00	444.90
RUB 🇷🇺	38.00	39.70
JPY 🇯🇵	25.80	26.30
KRW 🇰🇷	2.42	2.55

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 07  
2021.05.19.  
/ЛХАГВА ГАРАГ/

ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН МОГОЙ САРЫН ДӨРВӨН НОГООН УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:  
Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ.  
Наран ургах, шингэх:  
05.09-20.28  
Барилдлага:  
Үхэх  
Шүтэн барилдлага:  
Өтлөх үхэхүй  
Суудал:  
Огторгуй.

Аргын тооллын 5 сарын 19, Буд гараг. Билгийн тооллын 7, Их морь обтой, улаагчин туулай өдөр. Өдрийн наран 5 цаг 09 минутад мандан, 20 цаг 28 минутад жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адеус муулах, лусыг тахиx, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сэтгэлд сэтгэй газар очих, газар хааглах, ус булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үрээглэх буюу асуулахад тохиромжгүй.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

49.524

ЭДГЭРСЭН

42.721

НАС БАРСАН

221/12

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2331 (30)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

234

ЭДГЭРСЭН

2067

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 162,773,940

Эдгэрсэн

Нийт: 137,447,091

Нас барсан

Нийт: 3,375,573

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

БАТЛАГДСАН ТОХИОЛДОЛ

СҮҮЛИЙН 24 ЦАГТ 349 НИЙТ 49,524

ЭДГЭРСЭН

СҮҮЛИЙН 24 ЦАГТ 877 НИЙТ 42,721

НАС БАРАЛТ

/БУСАД ШАЛТГААНТ/ 7 НИЙТ 221/12

2021.05.18

11:00 ЦАГИЙН БАШДААР

ДЭВГЭЭ

ЦАХИМ ШУУДАНД

## ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА ХААГЧДЫГ “ЭХ ОРНЫ ТӨЛӨӨ МЕДАЛЬ”-ИАР ШАГНАВ



“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргүүдийн Цэргийн штабын офицер, ахлагч нар болон 2019 оны цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчид Баянзүрх хайрхны Бага зүрхний ар энгэрт доройтсон ойн сан бүхий газарт 20,000 шинэ модны тарьц суулгах ажилд оролцлоо.

Энэхүү арга хэмжээний үеэр албаа нэр төртэй хаасан цэргийн албыг биеэр

дүйцүүлэн хаагчдад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Эх орны төлөө-3” медалийг гардууллаа. Энэ үеэр Батлан хамгаалахын сайд хэлэхдээ “Цэргийн штаб, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчид 2020 онд сайжруулсан түлш савлах, айл өрхөөр зөвлөмж хүргэх, 2021 онд буюу энэ хүнд хэцүү нөхцөлд ард иргэдийнхээ эрүүл энхийн төлөө цар тахал өвчинтэй тэмцэх нэр их ажилд цаг наргүй маш сайн ажилласанд талархаж

буйгаа илэрхийллээ.

Нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабууд нь ногоон байгууламж байгуулах ажлаа үргэлжлүүлэн дүүрэг бүрд байрлах Зэвсэгт хүчний анги, нэгтгэлд шат дараатайгаар зохион байгуулан ажиллаж байна.

**СОНГИНОХАЙРХАН  
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ**

## 10 НЭР ТӨРЛИЙН 133 ШИРХЭГ, СУМ ГАЛТ ХЭРЭГЛЭЛИЙГ ИЛРҮҮЛЖ АЮУЛГҮЙ БОЛГОЛОО



### Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын болон захирагчийн тушаалаар томилогдсон “Тэсэрч дэлбэрэх зүйлийн хайгуул устгалын бүлэг” Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутаг дэвсгэрт 2021 оны 5 дугаар сарын 10, 12, 13-ны өдрүүдэд хайгуул, устгалын ажлыг зохион байгуулж 57мм УОР-281 сум 1 ширхэг, 85 мм УОФ 365 д/ц сум 17 ширхэг, 85 мм УБР-365 сум 3 ширхэг, 100 мм УБК сум 14 ширхэг, 120 мм ВОФ-834 сум 5 ширхэг, 122 мм М-21-ОФ сум 1 ширхэг, 122 мм ОФ-463М сум 3 ширхэг, 122 мм ОФ-463М сум 76 ширхэг, 125 мм ЗВБК 10 сум 11 ширхэг, онгоцны бөмбөг 2 ширхэг нийт 10 нэр төрлийн 133 ширхэг, сум галт хэрэглэлийг илрүүлж аюулгүй зайд тээвэрлэн галын аргаар 3 удаагийн тэсэлгээ хийж устган иргэдэд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийллээ.

Мөн тус бүлэг өнгөрсөн саруудад Дорнод аймгийн Халх гол сум, Сүхбаатар аймгийн Наран сумдад илэрсэн сум галт хэрэглэлийг тухай бүрт нь устгасан.



## ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЭВ

### Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Монголын төр, цэргийн зүтгэлтэн, Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин, БНМАУ-ын БХЯ-ны сайд, БХЯ-ны нэгдүгээр орлогч бөгөөд Жанжин штабын дарга, Цэргийн Ерөнхий дээд сургуулийн захирал, Хүндэт харуулын анхны дарга зэрэг нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай албан тушаалуудад үүрэг гүйцэтгэж, олноо “Жагсаалч, рапорт Ёндон” хэмээн алдаршсан хурандаа генерал Ж.Ёндонгийн гавьяаг мөнхжүүлэн алдаршуулах зорилгоор түүний төрсөн нутаг болох

Сүхбаатар аймгийн Баруун Урт хотноо “Хурандаа генерал Ж.Ёндонгийн дурсгалын хөшөө, цогцолбор”-ын шав тавих ёслолын ажиллагаа боллоо. Тус ангиас уг бүтээн байгуулалтад зориулж сэтгэлийн хандив өргөсөн бөгөөд ХЗЦК-ын Захирааны удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Л.Ганбаатар, “Ерөнхий цэрэг ассоциаци”-ийн удирдах зөвлөлийн гишүүн бэлтгэл хурандаа н.Эрдэнээ, н.Гантулга нар ирж талархал илэрхийлэн тус хөшөөний макетыг гардуулан өглөө.

**Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР**

## ХАНДЛАГА БА EQ ЧАДВАР



### Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

“Хандлагаа өөрчилж, хариуцлагаа нэмэгдүүлж” аяны хүрээнд Цаг уурын хөдөлгөөнт тасаг, Ахлагчийн зөвлөл санаачлан “Хандлага ба EQ чадвар” сэдвээр 2

цагийн хугацаатай сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг “Хүний нөөцийн менежерүүдийн нэгдсэн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Ариунболд явуулсан бөгөөд алба, тасгийн дарга нарт халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон танхимаар, бусад бүрэлдэхүүнд цахим хэлбэрээр явуулав.

## УХААЛАГ АРИУТГАЛЫН ХААЛГЫГ АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ



### Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Дэлхий нийтийг цочроож буй коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “ХАМТДАА СЭРГИЙЛБЕ ХАМТДАА ДАВЪЯ” уриалга дор нийт бие бүрэлдэхүүний халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах зорилгоор ухаалаг ариутгалын хаалгыг ашиглаж эхэллээ. Уг хаалга нь озоны ариутгал, цэнхэр гэрлийн ариутгал, хэт ягаан туяаны ариутгал, хэт авианы автомат шүршигч, хэт улаан туяаны индукцийн шүршигч гэх

зэрэг 3 төрлийн халдваргүйжүүлэлт ариутгалыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхээс гадна хаалганд ойртмогц автоматаар халууныг хэмжиж, маскаа зүүнээгүй зочинд “Та маскаа зүүнэ үү” гэж автоматаар сануулах гэх мэт олон давуу талтай.

Тус ангийн эмнэлгийн албанаас коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл зөвлөгөөг өдөр бүр ангийн группэд байршуулж шаардлагатай тохиолдолд утсаар бие бүрэлдэхүүнд зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч байна.

## АНГЛИ ХЭЛНИЙ ДАМЖАА ХИЧЭЭЛЛЭЖ БАЙНА



### Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Захирагчийн тушаалаар англи хэлний анхан шатны дамжаанд 10 цэргийн алба хаагч хамрагдаж байна. Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төвийн хичээлийн

хөтөлбөрийн дагуу явагдаж байгаа уг дамжааг англи хэлний багш, ахлагч А.Амарбаясгалан, туслах багш М.Од-Эрдэнэ нар хичээллүүлж байна.

**Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ**